

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН 4-Р БАГИЙН
НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ОЛОН УЛСЫН ШИНЭ
НИСЭХ БУУДАЛ, ШАТАХУУНЫ АГУУЛАХ”-ЫН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



2024 он

АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 1-1

1.1	ТӨСЛИЙН БАЙРШИЛ	1-1
1.2	ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД	1-1
1.2.1	Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)	1-1
1.2.2	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт (НУБИЭ) ХХК	1-1
1.3	НИСЭХ БУУДАЛД “НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД.....	1-2
1.3.1	Аэродром.....	1-2
1.3.2	Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга.....	1-2
1.3.3	Зорчигч үйлчлгээний барилга / Passenger terminal building	1-2
1.3.4	Аврах, гал унтраах албаны барилга, машин техник	1-3
1.3.5	Цэвэр ус хангамжийн байгууламж	1-3
1.3.6	Дулааны станц	1-4
1.3.7	Цахилгаан хангамж.....	1-4
1.3.8	Бохир ус цэвэрлэх байгууламж.....	1-5
1.3.9	Авто зогсоол, дулаан зогсоол	1-5
1.4	НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД.....	1-6
1.4.1	Шатахуун хангалтын алба.....	1-6

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 2-1

2.1	ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	2-1
2.2	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2-1	
2.3	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ / IMPLEMENTATION OF LANDSCAPING AND REHABILITATION PLAN.....	2-11
2.4	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	2-14
2.5	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-15
2.6	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-27
2.7	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	2-34
2.8	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	2-40
2.9	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /	2-44

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ 1

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2-1.БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардлын хураангуй	2-1
Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	2-1
Хүснэгт 2-3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	2-11
Хүснэгт 2-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-15
Хүснэгт 2-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-27
Хүснэгт 2-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт / Implementation of Environmental monitoring plan	2-34
Хүснэгт 2-7. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-40

Хүснэгт 2-8. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт2-44

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Байршил	1-1
Зураг 1-2. Хөөрч буух зурвас.....	1-2
Зураг 1-3. Ачаа, шууданийн үйлчилгээний барилга	1-2
Зураг 1-4. Аврах, гал унтраах барилга, машин техник	1-3
Зураг 1-5. Цэвэр усны байгууламж	1-4
Зураг 1-6. Дулааны цахилгаан станц.....	1-4
Зураг 1-7. Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга	1-5
Зураг 1-8. Цэвэрлэх байгууламж	1-5
Зураг 1-9. Авто болон дулаан зогсоол	1-6
Зураг 1-10. Шатахууны агуулахын байгууламж,агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20 м ³ -ийн хэвтээ цилиндр ган сав	1-6
Зураг 1-11. ТС-1 хадгалах 2000 м ³ -ын босоо цилиндр ган сав	1-7
Зураг 1-12. Түлш суллах хэвтээ цилиндр Т-503 маркийн 50 м ³ сав	1-7
Зураг 1-13. Шатахууны агуулахын насосны станц	1-8
Зураг 1-14. Галын усан сан, сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал	1-8
Зураг 1-15. Шатахуун ачих буулгах байгууламж.....	1-9

ОРШИЛ

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулгын хүрээнд боловсруулав.

Энэхүү биелэлтийн тайлан нь 2020 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 5 дахь жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан юм.


“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын 2020 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн хугацаа 2024 онд дуусаж байгаа бөгөөд 2025-2029 оны БОННУ-ний тайланг мэргэжлийн байгууллагаар боловсруулж байна.

Тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төсөл нь Төв аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн нутагт үйл ажиллагаагаа явуулж байна (Зураг 1-1).



Зураг 1-1. Байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын төвөөс 50 гаруй км, Зуунмод хотоос 8 км зайд Төв аймгийн Сэргэлэн сум, 4 дүгээр баг, Бөхөгийн хөндийд байрлана.

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

“Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудал нь олон улсын стандартыг хангасан 30 гаруй барилга байгууламжтай иж бүрэн цогцолбор юм. Эдгээр барилга байгууламжуудыг төсөл хэрэгжүүлэгч Иргэний нисэхийн ерөнхий газар болон Нью Улаанбаатартоо Интернэйшнл Эйрпорт ХХК-иуд өөрсдийн үйл ажиллагааны чиглэл тус бүрийн дагуу хариуцан ажиллаж байна.

1.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол улсын иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

1.2.2 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт (НУБИЭ) ХХК

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт (НУБИЭ) ХХК нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 261 дүгээр тогтоолоор Монгол талын 49 хувь, Япон талын 51 хувийн оролцоотойгоор 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан.

Тус компанийн 49 хувийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 150 дугаар тогтоолоор байгуулагдсан Хөшигийн Хөндийн Нисэх Онгоцны Буудал ТӨХХК эзэмшдэг бөгөөд 51 хувийг Японы Мицүбиши корпораци, Нарита Олон улсын нисэх буудал, ЖАТКО (Japan Airport Terminal Co., Ltd), ЖАЛУКС (JALUX Ltd.) компаниудын хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох Жапан Эйрпорт Менежмент ХХК эзэмшдэг.

1.3 НИСЭХ БУУДАЛД “НЬУ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

1.3.1 Аэродром

Том оврын агаарын хөлөг хөөрч, буух хоёр талын оролт, гаралттай, 3600 м урттай 45 м өргөнтэй зурвас, явгалах замтай. Аэродром нь ИКАО-ийн Хавсралт 14-ийн дагуу аэродромын лавлагаа код нь 4E буюу А330/В777 ангилалд тохирно. Энэ нь олон улсын нисэх буудлын хамгийн бага шаардлага, нисэх буудлын ашиглалтын аюулгүй байдлыг дээшлүүлэх I ангиллын нарийвчлалд нийцэх юм. Агаарын хөлгүүд хоёр чиглэлд хөөрдөг, буудаг байх салхины болон геологийн тооцоололтойгоор байгуулагдсан.



Зураг 1-2. Хөөрч буух зурвас

1.3.2 Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж буулгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах цогц үйлчилгээг Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага/ICAO/, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос /IATA/ гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үзүүлж байна.



Зураг 1-3. Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

Ачаа, шуудангийн үйлчилгээний барилгын хүчин чадал: 1) Байгууламжийн ашигтай талбай 3750 м²; 2) Жилд 11900 тонн карго ачаа, шуудан нэвтрүүлэх; 3) Аюултай ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м² талбайтай; 4) Үнэт ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м² талбайтай; 5) Хөргөлттэй агуулах 12 м²; 6) Хөлдөөгчтэй агуулах 44 м²; 7) Өндөр хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй.

1.3.3 Зорчигч үйлчлэгээний барилга / Passenger terminal building

Барилгажилтийн нийт талбай 53,726 м² ба үүний 37,000 м² нь үйлчилгээний зориулалттай.

Жилд 2,3 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай. Олон улсын зорчигчдын агаарын хөлөгт суух хүзүүвч 5, орон нутгийн зорчигчдын агаарын хөлөгт суух хүзүүвч 1, олон улсын бүртгэлийн 16, орон нутгийн бүртгэлийн 8 цэгтэй бөгөөд цаашид өргөтгөх боломжтой.

Нисэх буудлын барилгын фасад нь өндөр чанарын давхар шилэн хийцтэй тул гадна агаарын өндөр хэм дотор орон зайн агаарын хэмд нөлөөлөхгүй байхаар хийгдсэн. Шилэн дээвэртэй тул нэг ба хоёрдугаар давхарын танхимуудыг байгалийн гэрэлтүүлэгээр гэрэлтүүлдэг.



1.3.4 Аврах, гал унтраах албаны барилга, машин техник

ICAO-гийн 14-р хавсралт, Нисэх буудлын үйлчилгээний удирдамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу, 9 дүгээр категорийн нисэх буудлын хувьд гал түймрийн үед шаардагдах усны хамгийн бага хэмжээ нь 24300 литр байх бол хөөсөн уусмалын хувьд шүршилтийн хамгийн бага зэрэг нь (тухайн уусмалын үйлчлэлийн төвшин В байх нөхцөлд) 9000 литр/мин байна. Иймд хамгийн багадаа 8500 литр усны багтаамжтай, эсвэл минутанд 3000 литр уусмал шүрших шүршилтийн зэрэг бүхий 3 ширхэг аврах буюу гал түймэртэй тэмцэх машин техникийг нисэх буудлын хувьд төлөвлөсөн.

“Гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2 минутын дотор, агаарын хөлгүүдийн хөдөлгөөний талбай дахь бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой” гэсэн ICAO-гийн удирдамжийн шаардлагын дагуу гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, агаарын хөлөг зурвас руу гарах зориулалт бүхий явгалах замаар дамжин зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломжтой газар аврах, гал унтраах барилга байрлаж байна.



Зураг 1-4. Аврах, гал унтраах барилга, машин техник

1.3.5 Цэвэр ус хангамжийн байгууламж

Хөшигийн хөндийд байрлах усны эх үүсвэрийн гүний 3 худгаас ус олборлож, цэвэр ус хангамжийн байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд хүлээн авч 800 м³ хүчин чадалтай филтрэн системээр усыг цэвэршүүлж, ус хадгалах 2х400 м³ санд нөөцөлдөг. 4 өргөлтийн насосоор дамжуулан MNS900:2018 стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар нисэх буудлын бүс дэх барилга байгууламжуудыг 24 цагийн турш тасралтгүй хангадаг.



Зураг 1-5. Цэвэр усны байгууламж

1.3.6 Дулааны станц

Дулааны станц нисэх буудлын барилгаас 4 км зайд байрладаг.



Зураг 1-6. Дулааны цахилгаан станц

Нийт 38 автомашины зогсоолтой. 2016 оноос дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус бүр нь 14 МВт-ын хүчин чадал бүхий 3 зуухтай, нийт 42 МВт суурилагдсан хүчин чадалтай. Үүнээс 2 зуух нь халаалтын улиралд байнгын ажиллагаанд, 1 зуух нь бэлтгэл байдалд буюу нөөцөд байхаар төлөвлөгдсөн. Нисэх буудлын барилга, байгууламжуудын халаалт, агаар сэлгэлтийн системийн халаалтын хэрэгцээг хангах зорилгоор тус бүр нь 14 мегаватт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай, 150-170 градус параметртэй халуун ус гаргах 3 халаалтын зуухтай. Дулааны станц жилд ойролцоогоор 25,000 орчим тн хатуу нүүрсээр галлаж, 99.8 мян.м³ ус зарцуулж, 80 мянга орчим МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай.

1.3.7 Цахилгаан хангамж

Шинэ нисэх буудал нь 110/10кВ-ын “Хөшигт” дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10кВ-ын Налайх дэд станцаас 119 дүгээр агаарын шугамаар, 220/110/35кВ-ын Сонгино дэд станцаас 121, 122-р агаарын шугамаар, 110/10кВ-ын Бөхөг дэд станцаас 139, 140 агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2250 кВ чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.



Зураг 1-7. Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга

1.3.8 Бохир ус цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламж нь хоногт 800 м³ ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат удирдлагын системтэй. 2,2 км урт шугамтай, 2 өргөх станц, бохир усны 6 цооногтой.



Зураг 1-8. Цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламжид ирж буй бохир ус нь “Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, төвшинд тавих үндсэн шаардлага” MNS 4288:1995 стандартын шаардлага хангасан бохирдолтой усыг хүлээн авна. “Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлийн хүрээнд 10 төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг байна.

1.3.9 Авто зогсоол, дулаан зогсоол

Авто зогсоолын багтаамжийг агаарын хөлгийн хөдөлгөөний оргил цаг, нислэгийн урьдчилан тооцоолсон цагт үндэслэн тооцсон. Тус бүр 13 зогсоолтой 5 хос эгнээгээр халааслан нийт 6 халаасны зогсоолд 832 автомашин, такси зогсох боломжтой.



Зураг 1-9. Авто болон дулаан зогсоол

24 цагийн харуул хамгаалалт, камераар бүрэн тоноглогдсон 201 автомашины багтаамжтай 2 давхар дулаан зогсоолтой. Дулаан зогсоолын барилга нисэх буудлын барилгаас 400 метр зайд байрлаж байна.

1.4 НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

1.4.1 Шатахуун хангалтын алба

Шатахуун хангалтын алба нь шатахуун хадгалах босоо цилиндр 2000 м³-ийн 4 ширхэг ган сав, насосны станц, трансформатор, дизель цахилгаан үүсгүүрийн байр, галын усан сан 25 м³ савтай, тунадас хадгалах хэвтээ 10 м³ -ын 2 ширхэг далд байрлалтай сав, түлш суллах хэвтээ цилиндр 50 м³-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах хэвтээ цилиндр 20 м³- 1 савтай, харуулын байр, галын усан сан, хэвтээ сав парк, цэнэглэх талбай, шатахуун буулгах төхөөрөмж, ачих төхөөрөмж, ууршуулах талбай, цэвэрлэх байгууламж, галын гидрант, автомашины болон явган хүний зам талбай, сав парк өргөтгөлийн талбай зэрэг барилга байгууламж болон тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.

Шатахуун хадгалах сав: Шатахууны агуулах нь 2 га талбайтай, ТС хадгалах Т-201, Т-202, Т-203, Т-204 маркийн 2000 м³-ийн 4 ширхэг савтай.



Зураг 1-10. Шатахууны агуулахын байгууламж, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20 м³-ийн хэвтээ цилиндр ган сав

Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50 м³-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20 м³-ийн багтаамжтай 1 савтайгаар 2017 онд ашиглалтад орсон.

Т-201, Т-202, Т-203, Т-204 тус бүр 2000м³-ын босоо цилиндр ган савыг 2016 онд листийн аргаар угсарч, савыг суллаж ёроолын бохирдлыг цэвэрлэж савны туршилт, сорилтыг хийсэн. Савыг усаар дүүргэж даралт өгч битүүмжлэл болон ачааллыг шалгасан бөгөөд савны тоног төхөөрөмжийн гагнуурын хэсгийг тусгай хөөсрүүлэгч уусмал ашиглан шалгаж сорилт туршилтыг хийсэн. Савны тойргийн дагуу 6м тутамд хазайлт, суултыг тодорхойлсон ба шалгалтаар сайн дүнтэй гарч, ашиглах боломжтой гэсэн дүгнэлт өгсөн.

2000 м³ босоо цилиндр ган савны үндсэн тоног төхөөрөмжүүдэд нягт, температур хэмжигч төхөөрөмж, цахилгаан автомат хаалт, амьсгалах хавхлага, хамгаалах хавхлага,

шатахууны төвшин хэмжигч, температур хэмжигч, хэмжилтийн люк, дээж авах 3 хавхлага, хөөс, усаар бүтээгдэхүүний гадаргууг шүршин цацах шугам хоолой, орлого, зарлагын хоолой, автомат болон механик хаалтууд, цэвэрлэгээний люк, гэрлийн люк зэрэг орно.



Зураг 1-11. ТС-1 хадгалах 2000 м³-ын босоо цилиндр ган сав

Орчин үеийн автомат хэмжилтийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ба савны дүүргэлт, шатахууны температур, нягтыг автоматаар хэмжих хөвүүрт камертай. Савны төвшинг гурван төвшингээс хэмжих тоноглол, галын ус, хөөсний камер, дээж авах битүүмжлэлтэй тоног төхөөрөмжтэйгээрээ давуу талтай.

Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50 м³ багтаамжтай сав: Уг савны гэмтэл, аваар ослын үед сав суллах хэвтээ цилиндр түлш суллах D-503 маркийн 50м³-ийн 1 сав байна. Түлш суллах хэвтээ сав нь аюулгүй үйл ажиллагааг хангасан хаалт, оч баригч, үл буцаах хавхлага, хэмжилтийн люк, амьсгалах клапан, автомат төвшин хэмжигч, орлого, зарлагын шугам хоолой, оч баригч, автомат хаалт зэрэг тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.



Зураг 1-12. Түлш суллах хэвтээ цилиндр T-503 маркийн 50 м³ сав

Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м³-ийн багтаамжтай 1 сав байна. Дизель түлш хадгалах сав нь ил байрлалтай ба бүтээгдэхүүний шүүрэлт гоожилтоос хамгаалж газар талбайг бетондсон. Гал гарсан тохиолдолд галын хөдөлгөөнт хэрэгсэлтэй, ус болон хөөсөөр унтраахаар тоног төхөөрөмж, шүүрэлт гоожилтыг шингээж авах эсгий, элс агуулсан тоног төхөөрөмжийг ойролцоо байрлуулсан.

Насосны станц: Түлшний агуулах нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга, байгууламжийн гал тэсвэржилтийн зэргээр III зэрэглэлд хамаарна. III зэрэглэлийн агуулахын хувьд БНБД 21-03-04 насос станцын барилга дотор дизель цахилгаан үүсгүүрийг байрлуулахыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд нэг төрлийн хэрэгцээнээс илүүгүй багтаамж бүхий түлшний савыг барилгын цул ханын гадна талд, эсхүл шатдаггүй материалаар хийсэн байгууламжид суурилуулна.

Түлшний агуулах нь 2017 онд ашиглалтад орсон гидрант насос Р-301, Р-302, Р-303, Р-304 маркийн 227 м³/цаг хүчин чадалтай 4 ширхэг, сав хоорондын D-503 маркийн 50 м³/цаг 1 ширхэг насостай. БНБД 21-03-04 агуулахын галын аюулгүйн байршлын стандартын 7.4 дүгээр заалтын дагуу тус агуулахын насосны станцын барилгын насосны тэсрэлтээс хамгаалагдсан цахилгаан хөдөлгүүр болон дотоод шаталтат хөдөлгүүрийн өрөө нь насосны өрөөнөөс 1 төрлийн галаас хамгаалах цул ханаар тусгаарлагдан хийгдсэн байна.



Зураг 1-13. Шатахууны агуулахын насосны станц

Галын усан сан: ТС түлш хадгалах 2000 м³-ийн багтаамжтай савнууд нь сав хөргөх суурин төхөөрөмжөөр тоноглогдсон.



Зураг 1-14. Галын усан сан, сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал

Савны дээд бүсэд байрлах, тодорхой хэсгүүдэд хуваагдсан, ус шүрших (усыг тойруулан шүрших хэрэгслээр тоноглогдсон хоолой) цагираг, цагиргийг галын ус дамжуулах хоолойтой холбогдсон босоо болон хэвтээ хуурай хоолойнууд, гар ажиллагаатай хаалтуудаас бүрддэг. Систем нь гал түймэр гарсан тохиолдолд савны байрлалаас хамааруулан савны гадаргууг бүтнээр, хагасыг болон дөрөвний нэгийг хөргөх боломжтой. Галын усан сан нь 500 м³/цаг далд байрласан галын усан сантай, гүний усаар хангагддаг. БНБД21-03-04 агуулахын галын аюулгүйн норм дүрмийн 8.6 дугаар заалтын дагуу 1000-3000 м³-ын багтаамжтай шатахуун хадгалах савнуудад хөөсний генератор суурилуулж галын техник хэрэгсэл холбох зориулалтын хэрэгсэл бүхий төгсгөлийг нь далангийн гадна гаргасан хоолойд холбосон.

Шатахуун ачих буулгах байгууламж: БНБД21-03-04 ын 5.7, 5.8 зэрэг заалтын дагуу ачиж буулгах хэсгийн талбай нь ус үл нэвтрэх хатуу гадаргуутай, 0.2м-ээс багагүй өндөр хашлагаар битүү хүрээлэгдсэн, шингэнийг бохирын суваг, цуглуулга урсгах зориулалтаар 2 хувиас багагүй налуутайгаар хийгдсэн.

Ачих буулгах байгууламжийн тавцангийн шатнуудыг тавцангийн 2 төгсгөл, шулуун хэсэгт хоорондоо 100 м-ээс илүүгүй зайд байрлуулна. Шатны өргөн нь нь 0.7 м-ээс багагүй, 1:1-ээс илүүгүй өгсүүр зэрэг заалтыг шаардлага хангасан байна. Тус агуулах нь Z-106 маркийн 2300 л/мин, Z-101 маркийн 1900 л/мин, Z-102 маркийн 1900 л/мин, Z-103 маркийн 2300 л/мин ачих, буулгах хүчин чадалтай 4ш төхөөрөмжөөс бүрдэнэ.

Агаарын хөлгийг сумлах ажиллагаа нь зорчигч үйлчилгээний барилгын агаарын хөлгийн зургаан зогсоол дээр байрлах арван дөрвөн ширхэг гидрантын хавхлагаас түлш түгээх зориулалтын диспенсэр авто машинаар хийгдэнэ.



Зураг 1-15. Шатахуун ачих буулгах байгууламж

Нэг худаг нь нэг минутад 1,000 галлон буюу 3,780 литр хүртэл шахах техникийн хүчин чадалтай. Гурван агаарын хөлөгт нэгэн зэрэг сумлагаа хийх боломжтой.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1 ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Хүснэгт 2-1.БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал, ₮
1.	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	207,140,911
2.	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт	412,430,000
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	45,899,100
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	203,899,100
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	8,000,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7,928,360
<i>Нийт зардал</i>		885,297,471

2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК					
Агаарын чанар					
1.	Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах. Дулааны станцын яндангийн дагуу агаарын чанарын шинжилгээ хийлгэх	-	Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг хянах зорилгоор жилд 2 удаа хэмжилт хийлгэсэн. -Тоос, тоосонцор, SO ₂ , NO ₂ болон дуу чимээний хэмжилтийг 2024.05.29-ний өдөр ЦҮОШГ-ын БОХЗТЛ-иор гүйцэтгүүлсэн. Хэмжилтийн үр дүн “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй (Хавсралт. Хуудас 2) -Тоосонцрын хэмжилт, хорт хийн (CO, SO ₂ , NO ₂ , C ₆ H ₆ , C ₇ H ₈ , C ₆ H ₄) хэмжилт болон дуу чимээний хэмжилтийг 2024 оны 10 дугаар сарын 28-наас 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд “Хэлт энд Сэфти Солюшинс” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Хэмжилтийн үр дүн “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 5885:2008. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” стандартуудын хүлцэх агууламжаас хэтрээгүй (Хавсралт. Хуудас 3)	100
2.		Утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, үйл ажиллагааг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд солих	163,944,000	2024 оны зуны урсгал засвараар Дулааны станцын 1300 ш уутат шүүлтүүрийн уутыг шинэчлэн сольж, зуухны бэлэн байдлыг хангасан.	100

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
3.	Дулааны станцад нийлүүлдэг нүүрсний чанар алдагдснаас үүсэх агаарын бохирдол	Итгэмжлэгдсэн лабораториор нүүрсний шинжилгээ хийлгүүлэх, нүүрсний чанарын горимд хяналт тавих. Нүүрс дулааны станцын стандартад нийцэхгүй тохиолдолд нүүрсийг солих арга хэмжээ авах	-		100
4.	Барилга байгууламжийн хөргөлтийн системээс	Хөргөлтийн системийн R22 хөргөх бодисыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн,	38,000,000	<p>-Нисэх буудлын Дулааны станцын 2024-2025 оны халаалтын улиралд хэрэглэх нүүрсийг “Эн Жи Эм Эй” ХХК-иас “Худалдах, худалдан авах” гэрээгээр нийлүүлж байна. Тус компани нь нийлүүлж буй нүүрсээ Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Түлшний шинжилгээний лабораториор 11, 12 дугаар сард шинжлүүлсэн. (Хавсралт. Хуудас 4-5).</p> <p>-Нүүрсний шаталтаас шалтгаалж, агаарын бохирдол үүсэхээс сэргийлж, дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийлүүлэгдэж байгаа нүүрсний чанарыг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэхээс гадна зуухны шаталтыг технологийн горимын дагуу дутуу шаталтгүй явуулж байна.</p> <p>-2024 онд Зорчигч үйлчилгээний барилгын 6 ширхэг хүзүүвчний R22 шингэнээр ажилладаг хөргөлтийн тоноглолыг шинээр R-410A бодисоор сольсон.</p> <p>Бусад барилгуудыг үе шаттайгаар шинэчилнэ.</p>	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
	агаарын чанар, озоны давхаргад үзүүлэх сөрөг нөлөө үзүүлэх	байгаль орчинд ээлтэй хөргөх бодисоор шинэчлэх			
5.	Хөрс, ургамлан бүрхэвчийн элэгдэл, эвдрэл бохирдол	Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалах. Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт тавих	-	Нисэх буудал орчимд хөрсний эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлж, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьдаг.	100
6.		Нисэх буудлын орчинд төрийн болон бусад байгууллагууд шинээр барилга байгууламж баригдах тохиолдолд (НУБИЭ ХХК барилга барихгүй) хуулсан газрын шимт хөрсийг дахин ашиглах, барилгажилт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх, зүлэгжүүлэх ажилд хяналт, шаардлага тавих	-	Одоогоор нисэх буудлын орчимд шинээр барилга байгууламж баригдаагүй. Хэрэв шинээр барилга байгууламж баригдах тохиолдолд барилгын газар шорооны ажлын үед хуулсан газрын шимт хөрсийн дахин ашиглах, барилгажилт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт, зүлэгжүүлэлтийн ажилд хяналт тавьж ажиллана.	100
Усан орчин					

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
7.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	5,196,911	-НУБИЭ ХХК нь 2024 оны 06 дугаар сард Туул голын сав газартай 24/29 дугаартай “Ус ашиглах гэрээ”-г байгуулан ажиллаж байна. -2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн №90 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт-тэй -2024 онд дулааны үйлдвэрлэлд 1,834 м³, ногоон байгууламжийн усалгаанд 1,785 м³, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд 40,681 м³ ус ашиглаж нийт 5,196,911.16 төгрөгийг төлсөн. (Хавсралт. Хуудас 6-14)	100
8.		Усны тоолуур баталгаажуулах	-	Нисэх буудлын 3 худаг нь Стандарт хэмжилзүйн газрын № ЭУ 104334, № ЭУ 104164, № ЭУ104165 тоот WMAP-80 загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээтэй. Тус гэрчилгээ нь 2025.08.17-ны өдөр хүртэл хүчинтэй.	100
9.		Барилга байгууламжуудын усны тоолуурын баталгаажуулалтанд хяналт тавих	-	Газар доорх усны түвшин хэмжих багажийн судалгаа хийж, үнийн санал авсан. Техникийн шаардлагыг тодорхойлж, зардлыг 2025 оны төсөвт батлуулсан	100
10.	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалсан хашаа тэмдэгжүүлэлтийг эвдэрсэн тохиолдолд засаж сайжруулах, хянах	-	Усны эх үүсвэрийг хамгаалсан хаягжилтад эвдрэл гэмтэл гараагүй хэвийн байна. 	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
11.	Борооны усаар хог хаягдал угаагдан хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанарт өөрчлөлт оруулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүдэд шаардагдах материалыг бэлэн байлгах	-	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүдэд асгарч алдагдсан тохиолдолд шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавьдаг.	100
12.	Бохир ус асгарч хүрээлэн буй орчныг бохирдуулах, хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, аюулгүй ажиллагааг хангах Бохир усны шугам хоолой, худгийн үзлэг шалгалтыг өдөр тутам хийж гүйцэтгэх, шугам хоолойн дуран оношилгоо, угаалга цэвэрлэгээ хийх	-	-Ус хангамж, ариутгах татуургын системийн техник ашиглалтын дүрмийн дагуу НУБИЭ ХХК-ийн эзэмшлийн бохир усны шугам хоолойд өдөр тутмын үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэсэн ба гэмтэл, доголдол илрээгүй. -Хөрсөнд бохир ус нэвчих, шугам хоолойноос шалтгаалсан гэнэтийн аваар, осол гарахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор 2024 оны 5 болон 10 дугаар сард тус бүр 1.9 км шугам, 61 худгийн дуран оношилгоо, 2024 оны 10 дугаар сард бохир усны 1.9 км шугам, 222 м ² бохир ус хүлээн авах санг угааж цэвэрлэсэн.	100
13.	Цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн бохир уснаас хүрээлэн буй орчин бохирдох, хөрс, ургамал, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх	Туул голын сав газрын захиргаанаас “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл” сунгуулах	-	-Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар Хаягдал усны дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтэд үндэслэж Туул голын сав газрын захиргааны 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 22/03 тоот “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл”-ийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр сунгуулсан.	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
14.	Хүрээлэн буй орчны бохирдол, хүн мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх	Хаягдал усны зөвшөөрөл дүгнэлт гаргуулах, цэвэрлэгдсэн усыг эргүүлэн ашиглах	-	2024 онд нисэх буудлын хэмжээнд цэвэрлэх байгууламжаас гарсан 1,199.27 м ³ цэвэрлэгдсэн бохир усыг аэродромын зам талбайн цэвэрлэгээ, агаарын хөлгийн бохир тээвэрлэгч машины ёмкостын цэвэрлэгээ, цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, цэвэрлэх байгууламжийн ариун цэврийн өрөөний суултуурын ус зэрэгт дахин ашигласан.	100
НУБИЭ ХХК-ийн Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал				207,140,911 ₮	
ИНЕГ, ИНҮТ-ИЙН ШАТАХУУНЫ АГУУЛАХЫН АЛБА					
15.	Шатахууны агуулахаас үүсэх агаарын бохирдол	Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны хяналт	-	Шатахууны агуулахын сав түүний тоноглолын битүүмжлэл өндөр түвшинд хангагдсан учир шатахууны ууршилтгүй, сар бүр JIG-2 стандартын дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.	100


БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
16.	Цэнэглэх үеийн агаарын бохирдол	Зураг авалтаар гарсан дүгнэлтэд үндэслэн шатахууны агуулахыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох	-	Шатахуун хангалтын албаны Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх тоног төхөөрөмж нь битүүмжлэл сайтай сүүлийн үеийн технологи ашигладаг учир шатахууны ууршилтгүй сумлаагааг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.	100

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
17.	Түлшний шаталтаас үүсэх хийгээр агаар бохирдох	Тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тогтмол хийх, шатах тослох материалын чанарын үзлэгийг хийж, холбогдох арга хэмжээг авах	-	Агаарын хөлөг шатахуунаар цэнэглэх сумлагч автомашинд шатахуун ачих тоног төхөөрөмж нь доогуур ачилтын хоолойтой, торхны дээд люкний (лүүк) битүүмжлэл сайн учир шатахууны ууршилтгүй ачилтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.	100



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
18.	Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаар хөрс бохирдох	Шатахууны агуулахад хийсэн зураг авалтын үр дүн, зөвлөмжийг дагаж ажиллах	-	 <p>The image shows two documents. The left one is a 'ТЕХНИК АШИГЛАЛТЫН ПАСПОРТ №' (Technical Passport) for a gas separator. The right one is an inspection report with handwritten entries in a table, including dates and names of inspectors.</p>	100
19.	Газрын тосны бүтээгдэхүүний асгаралт	Осол эрсдэлийн дүрмийн дагуух бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сепараторт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг.	100
20.		Нефтийн бүтээгдэхүүний асгаралтын дараа	-	Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна. Агуулахын ГТБ-ээр	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт	%
		хөрсөөр дамжин гүний усны бохирдол үүссэн эсэхийг тодорхойлон холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх		бохирдсон ус цуглуулах системийн байгуулалтын схем зургийг хавсаргав.	
21.	Газрын тосны бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж ургамалжилтад нөлөө үзүүлэх, бохирдуулах, бохирдсон ургамлыг идсэн мал амьтан хордох	Хөрс болон усан орчинд газрын тосны бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шингээн авах шаардлагатай. Тайланд өгсөн зөмлөмжийн дагуу ажиллах, шаардлагатай материалыг бэлэн байлгах	-	Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сепараторт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд зарцуулсан нийт дүн				207,140,911 ₮	

2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ / IMPLEMENTATION OF LANDSCAPING AND REHABILITATION PLAN

Хүснэгт 2-3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжилт
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК					
1.	Зүлэгжүүлэх	Зүлэгжүүлэх талбайн хөрс бэлтгэх, олон наст зүлэг тарих	Нисэх буудлын автомашины зогсоолын урд хэсэг	360,000,000	<p>“Бат Өндөр Хайрхан” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан, нисэх буудлын авто зогсоолын орчмын нийт 15,455 м² талбайн өнгөн хөрсийг бүрэн шинэчилж, зүлэгжүүлсэн.</p> 
2.	Тарьсан мод, зүлэгний арчилгаа хамгаалалт	Нисэх буудал орчим тарьсан мод, зүлэгний арчилгаа, усалгаа, тайралт, хамгаалалтыг хийх, хяналт тавих	Нисэх буудлын нийт ногоон байгууламжийн хүрээнд	28,430,000	<p>-Тарьсан модыг услах, бордох, тайралт хийх ажлыг “Аполло Бьюлдинг Сервис Монголия” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн. -Нисэх буудлын автомашины зогсоол орчимд тарьсан зүлэгний усалгаа, тайралтыг “Бат Өндөр Хайрхан” ХХК хариуцан гүйцэтгэсэн.</p>

№	Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжилт
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК					
3.	Мод тарих	Компанийн ажилтнуудыг хамруулсан мод тарих ажлыг зохион байгуулах	Төв аймгийн Сэргэлэн суманд	24,000,000	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нисэх буудлын авто зогсоолын зүүн хойд хэсэгт хаврын мод тарих өдөрлөгөөр 2000 ширхэг хайлаас, намрын мод тарилтаар 500 ш мод тарьсан.</p>   

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжилт
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК					
					
		НУБИЭ ХХК-ийн Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн нийт дүн (₮)			412,430,000 ₮

2.4 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


Нисэх буудлын үйл ажиллагаагаар Түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай гэж БОННУ тайланд тусгасан байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасан байдаг.

Одоогийн байдлаар нисэх буудлын үйл ажиллагаанаас хамаарч Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөлөл илрээгүй учраас Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй.

2.5 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
1.	Их хэмжээний бороо, үер, ус, цаг уурын гаралтай байгалийн гамшигаас үүсэх аюул	2023 оны Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу байгууллагын 2024-2025 оны “Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжилтийг хянаж ажиллах	<p>НУБИЭ ХХК-ийн Нисэх буудлын Ерөнхий зааврын 3.7.5-р бүлэгт Байгалийн гамшиг гэсэн газар хөдлөлт, их хэмжээний цас, цасан шуурга, хүчтэй салхи, үер, хээрийн түймэр зэрэг үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон байдаг бөгөөд үүнийг баримталж ажилладаг.</p> 	100
2.	ХАБЭА-н зааварчилгаа мөрддөггүйгээс үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол болох	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах, ажилтнуудад урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт явуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажилчдад хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулдаг.	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
3.	ЗТСайдын 2016 оны 48-р тушаалаар баталсан “Агаарын хөлөг шувуу мал, амьтадтай мөргөлдөх аюулаас Сэргийлэх хөтөлбөр”-ийг үндэслэн Төв Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллах “Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл”-ийн хүрээнд болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх	-Аэродром орчмын болон ойртолтын “А” бүсэд шувуу үүрлэсэн тохиолдлуудыг илрүүлэх, үүрийг буулгах, шувуу дахин үүр засах нөхцөлийг арилгах	 <p>Агаарын хөлгийн хоолой, апрон талбайн ойр орчимд болон агаарын хөлгийн ойртолтын бүсэд шувуу үүрлэж тоо толгой нь нэмэгдэхээс сэргийлж 2024 онд нийт 4 удаагийн үүр буулгах ажлын хүрээнд нийт 9 ш үүрийг буулгасан.</p> 	100
4.		Нисэх буудлын орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж зайлуулах, Сэргэлэн сумын төвлөрсөн хогийн цэгүүдэд тогтмол үзлэг хяналт хийх	<p>Нисэх буудлын хэмжээнд хог хаягдлыг дараах байдлаар ангилж гэрээт компанитай хамтарч ажилладаг.</p> <p>-Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, шатаах ажлыг (эмнэлгийн хог хаягдал, шатамхай болон зэвсгийн чанартай хог хаягдал, химийн хог хаягдал, лаг, механик хог хаягдал зэрэг) Элемент ХХК</p> <p>-Ангилалгүй хог хаягдлыг (ангилагдахгүй хог хаягдал, дахивар, хүнсний, техникийн шингэн, тос масло зэргийг) Элемент Медикал ХХК</p> <p>-Нисэх буудлын дулааны станцын “Үнс” тээврийг “Төв аймгийн хот тохижуулах газар”-тай байгуулсан гэрээний дагуу тус бүр тогтсон хугацаанд тээвэрлүүлдэг.</p>	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
5.		Төв аймгийн цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн бохир усыг тунгаах усан санд шувуу суулгахгүй байх арга хэмжээг тодорхойлох, тус арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Усан санд хуваарийн дагуу тогтмол үзлэг хийж, үргээлэг хийдэг.	100
6.	Нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын нөлөөллийн судалгаа, мониторинг хийх, судалгааны үр дүнд тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээ авах	Нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын нөлөөллийн судалгаа, мониторинг хийх, судалгааны үр дүнд тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээ авах	<p>-“Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ-тай “Аэродромын талбай, нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын мониторинг судалгаа”-ны ажлыг 2021 оноос хойш хамтарч ажиллаж байна.</p> <p>8 дугаар сарын явцын тайланд 62 зүйл шувуу, 7 зүйл хөхтөн амьтан тохиолдсон ба харьцангуй олон давтамжтайгаар хон хон хэрээ (n=99), эвэрт болжмор (n=80), Монгол болжмор (n=59), сохор элээ (n=41), шилийн сар (n=38) тэмдэглэгдсэн бөгөөд, эрсдэлийн үнэлгээг тодорхойлсон. Тайлангийн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан ажлуудыг “Чингис хаан” нисэх буудал нь хэрэгжүүлж ажилладаг. Мөн 5-р сард 3 ш автомат камерыг байрлуулсан. Нийт 9,556 зураг бүртгэгдсэнээс шувуу, хөхтөн амьтдын 249 тохиолдол бүртгэгдсэн.</p> <p>1. Шувууны үзлэг хяналт</p> <p>Аэродромын аюулгүйн хамгаалалттай “А” бүсэд хамгаалалттай хашааны дотор үзлэг хяналт тавихаас гадна агаарын хөлгийн ойртолтын “Б” бүсэд Аэродромын хяналтын цэгээс 15 км радиус дотор үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүд, барилга байгууламж, тусгай цэгүүдээр сар бүр үзлэг хийж байсныг эрчимжүүлж долоо хоног бүр хийдэг болсон.</p> <p>2. Нисэхийн мэдээллийн үйлчилгээ буюу NOTAM мэдээ</p> <p>3. Өвс хадалт</p> <p>Аэродромын аюулгүйн хамгаалалттай бүсэд жижиг шувууны тоо толгой нэмэгдэхээс сэргийлэх, өндөр өвсөн дунд хоргодох, үүрлэх нөхцөлийг бууруулах зорилгоор хашаан доторх талбайд өвс хадах ажлыг хийдэг.</p>	100

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				



4. Өвсний өндрийг хянах

Өвсний өндрийг хянах, жижиг шувуудын бөөгнөрлийг бууруулах зорилгоор хамгаалалттай хашаан доторх өнжмөл өвс шатаах ажлыг хийдэг.



5. Шавж, мэрэгч амьтдын устгал

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
			<p>Өдөр шөнийн идэвхтэй махчин шувуудын гол идэш тэжээл нь жижиг хөхтөн буюу мэрэгч амьтад байдаг бөгөөд эдгээр шувуудын анхаарлыг татах, зурвасын ойр орчмоор орж ирэх тохиолдлыг бууруулах зорилгоор жил бүр 2 удаа “Улаанбаатар Ариутгал” ХХК-р нисэх буудлын аэродромын бүсийн 600 га талбайд шавж, мэрэгч устгалын хор цацуулдаг. /45,899,100 ₮/ Гэрээг хавсаргав. (Хавсралт. Хуудас 18)</p>	
				
			6. Шувуу барих тор	
				

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				

7. Шувуулахуй буюу сургасан махчин шувуу

2024 оны I улирлаас сургасан махчин шувуугаар бусад шувуу, зэрлэг амьтныг үргээх, бариулах, дайжуулах аргыг туршиж эхэлсэн. “Чингис Хаан” ОУНБ-ын Аэродромын газарт Шонхор шувууг байрлуулж, сургаж байна. Одоогоор тухайн шонхор нь хөхвөр тагтаа, хадны тагтаа зэрэг шувуу руу сул чөлөөтэй нисэж барьдаг болсон.




8. Цусны толбо шинжлүүлэх

2024 оноос агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн, цусны толботой бууж ирсэн тохиолдолд шувууны зүйлийг тодорхойлуулахаар генетикийн лабораторитой гэрээ байгуулсан /МУИС-ийн молекул биологи, генетикийн лаборатори/. Шувууны зүйлийг лабораториор шинжлүүлж зүйлийг тодорхойлох нь тухайн зүйлийн шувуу аль нисэх буудлын орчимд ажиглагддаг, мөргөлт хаана болсон байх боломжтой гэдгийг тодорхойлох ач холбогдолтой.

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
				
<p>9. Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл</p>				
<p>Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл 2021 онд байгуулагдсан бөгөөд тус хурлаар өмнөх оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулж, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж ажилладаг.</p>				
<p>10. Шувууны бүртгэлийн eBird аппликейшн</p>				
<p>Шувууны хяналтын бүртгэлийг сайжруулах зорилгоор 2023 оноос тус аппликейшнийг шувууны хяналтын ажилтнууд ашиглаж эхэлсэн бөгөөд 2024 оны хагас жилийн хувьд 3119 удаагийн бүртгэл хөтөлж 26 зүйлийн шувуу ажигласан байна.</p>				


БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
		Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК		



7.	Нисэх буудлын орчимд үхсэн мал, амьтны сэг зэмийг халдваргүйжүүлэх, зайлуулах	2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 18 удаагийн давтамжаар 400 гаруй үхсэн мал амьтны сэг зэмийг зайлуулж, халдвар тархах, шувууд цугларахаас сэргийлсэн.	100
----	---	---	-----

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
				
8.		Олон улсад ашиглаж буй шувуу үргээх дэвшилтэт технологийг судлах	Олон улсад өргөн хэрэглэгддэг шувуу үргээх дуу чимээ гаргах төхөөрөмж, дохионы буу зэргийг ашиглаж байна.	100
9.	Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх тохиолдлыг бууруулна	Агаарын хөлөгтэй мөргөлдөх өндөр эрсдэл бүхий шувуу, мал, амьтны зүйлүүд улирлын чанартай өөрчлөгддөгтэй холбоотойгоор, улирал бүрийн мониторинг хийх, нарийвчлан тогтоох. Олон улсад ашиглаж буй шувуу үргээх дэвшилтэт технологийг судлах	<p>-“Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ-тай “Аэродромын талбай, нисэх буудал орчмын шувуу, хөхтөн амьтдын мониторинг судалгаа”-ны ажлыг 2021 оноос хойш хамтарч ажиллаж байгаа бөгөөд хавар намрын улирал буюу шувууны нүүдлийн үед жил бүр мониторинг хийлгэдэг.</p> <p>-Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэн 2024 оны хагас жилийн байдлаар 2533 удаагийн ажиглалт, 5 маршрутын дагуу нийт 3410 удаа үзлэг хяналт хийсэн. 2023 оны хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад 57 хувиар өссөн.</p> <p>-НУБИЭ ХХК-ийн “Нисэх буудлын ерөнхий заавар”-ын Бүлэг 2.15-т “Мал амьтан, Шувууны Аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийг байнгын баримталж ажилладаг.</p>	100
10.	Аэродромын аюулгүй ажиллагааг хангах	Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгийг үндэслэн тодорхойлсон аюулгүй ажиллагааны бодлого, зорилтуудын хүрээнд Аэродромын аюулгүй ажиллагааг иргэний нисэхийн салбарын байгууллага, нэгжүүдийн хамтын ажиллагаанд тулгуурлан аюулыг	<p>-Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгийг үндэслэн боловсруулсан “Нисэх буудлын ерөнхий заавар”-ын 4.1.4 “Эрсдэлийн удирдлага”-ыг баримтлан НУБИЭ ХХК-ийн Аюулгүй ажиллагааны төлөвлөлтийн хэлтсээс аливаа аюулыг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй эрсдэлийг удирдаж ажилладаг.</p> <p>- Үйл ажиллагаанд гарсан үл нийцлийг бүртгэж, аюул, эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлж долоо хоног бүрийн Пүрэв гарагт “Үл нийцлийн залруулгын хэлэлцүүлэг” хурлыг тогтмол зохион байгуулж,</p>	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
		илрүүлэх, түүний болзошгүй эрсдэлийг удирдах	илэрсэн үл нийцэлд холбогдох залруулгыг хийж, аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг.	
11.		Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг инженер техникийн болон галын мэргэжлийн алба хаагчдаас бүрдсэн баг томилон Нисэх буудлын барилга байгууламжуудад зохион байгуулах	Нисэх буудлын үйл ажиллагаа удирдлагын газрын Аврах, гал унтраах хэлтсийн бие бүрэлдэхүүн, галын бүлгэм хамтран нисэх буудлын барилга байгууламжуудад гарсан гал түймрийг унтраах дасгал сургуулилтыг сар бүр зохион байгуулдаг. Галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэгийг Нисэх буудлын харьяа 11 барилга байгууламжуудад, ИНҮТ-ийн 4 байгууламжид зохион байгуулж, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласан.	100
12.		MNS 5566:2020 стандартын дагуу байрлуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлд нөхөн хангалт, засвар үйлчилгээ хийх	Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажилладаг тухай, MNS 5566:2020 стандартын дагуу байрлуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлд нөхөн хангалт тогтмол хийн ажиллаж байна.	100
	Гал түймрийн болзошгүй аюул		-ИНД 139-д заасны дагуу Аэродромын галын зэрэглэлийн ханган ажиллаж байна, мөн 13-н байгууламжид АГУХ-ийн бие бүрэлдэхүүн, галын бүлгэм хамтарсан дасгал сургуулилалт зохион байгуулж ажилласан. -682 ажилтанд Галын аюулгүй байдал, гал унтраах талаарх сургалтыг зохион байгуулсан.	
13.		Аэродромын галын зэрэглэлийн хангалт. Гал унтраах сургалт, үзүүлэх сургууль, дадлагажих үйл ажиллагаа		100
14.	Шатахууны агуулахын ашиглалтын үед үүсч болох эрсдэл	Шатахуун ачих, буулгах талбайд асарсан тохиолдолд зориулалтын сувгаар ууршуулах талбайд орно.	Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай учир шатахуун асарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос	100

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
			<p>ялгах сепараторт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.</p> <p>2024 оны 04-р сарын 30-ны өдөр “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-нд тодотгол хийн, Төв аймгийн ОБГ-аар хянуулж, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>	
15.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүссэн осол бүртгэгдээгүй.	100
16.	Гал түймрийн болзошгүй аюул	“Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-нд тодотгол хийж, хэрэгжилтийг хангаж ажиллах Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах	<p>-НУБИЭ ХХК-ийн 11 барилга байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд тодотгол хийж, Төв аймгийн ОБГ-аар батлуулсан бөгөөд гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг тогтмол хангаж ажилладаг.</p> <p>-2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-нд тодотгол хийн, Төв аймгийн ОБГ-аар хянуулж, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>	100



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН - 2024

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК				
				
			<p>2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан “ШХА-ны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн, Төв аймгийн ОБГ-аар хянуулж, албаны даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>	
17.	Тоног төхөөрөмжийн ажиллагаа алдагдах	Шатахууны агуулах, дохиолол холбооны системийн найдвартай ажиллагаанд үзлэг шалгалт хийж, холбогдох албан дүгнэлтүүдийг гаргуулж байх	<p>-НУБИЭ ХХК-ийн 11 барилга байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд тодотгол хийж Төв аймгийн ОБГ-аар батлуулсан. -Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг тогтмол хангаж ажилладаг.</p>	100
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд зарцуулсан нийт зардал			45,899,100 ₮	

2.6 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Төрөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)	%
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК					
1 Дахивар					
